




ХЭНТИЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2025 IV



khentii.nso.mn



ЧИНГИС ХОТ
2025

ХЭНТИЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГЭМ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2025

4 сар

Чингис хот
2025

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

Сар: I, II, III, IV, V ... г.м

Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII

Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

* урьдчилсан гүйцэтгэл

III. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000	мл	миллилитр
сая	=10 ⁶	л	литр
тэрбум	=10 ⁹	г	грамм
их наяд	=10 ¹²	кг	килограмм
мян.	мянга	цн	центнер
%	хувь	т	тонн
мм	миллиметр	Вт	ватт
см	сантиметр	кВт.ц	киловатт цаг
дм	дециметр	кал	калори
м	метр	ккал	килокалори
км	километр	Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
м ²	метр квадрат	с	секунд
дм ²	дециметр квадрат	мин	минут
км ²	километр квадрат	мкг/м ³	микрограмм метр куб
м ³	метр куб	м/с	метр секунд
га	гектар	ш	ширхэг

┌ Үүнээс гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	4
Үндсэн үзүүлэлт	6
I. Хөдөлмөр	6-8
II. Эрүүл мэнд	9-11
III. Нийгмийн халамж, даатгал	12-14
IV. Гэмт хэрэг	15-17
V. Мөнгө, зээл	18-20
VI. Төсөв	21-23
VII. Үнэ	24-25
VIII. Мал аж ахуй	26-28
IX. Аж үйлдвэр	29-31
X. Цаг уур	32

БҮЛЭГ:

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

I.	ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	Ц. САЙХАНЧУЛУУН
II.	ЭРҮҮЛ МЭНД	Н. НАРАНГҮНЖ
III.	НИЙГМИЙН ХАЛАМЖ, ДААТГАЛ	Н. НАРАНГҮНЖ
IV.	ГЭМТ ХЭРЭГ	Ц. САЙХАНЧУЛУУН
V.	МӨНГӨ, ЗЭЭЛ	Ц. САЙХАНЧУЛУУН
VI.	ТӨСӨВ	Ц. САЙХАНЧУЛУУН
VII.	ҮНЭ	Н. НАРАНГҮНЖ
VIII.	МАЛ АЖ АХУЙ	Ц. БАТХИШИГ
IX.	АЖ ҮЙЛДВЭР	Б. ОНОНЧИМЭГ
X.	ЦАГ УУР	Ц. БАТХИШИГ




ХӨДӨЛМӨР

Бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 38.7 хувиар буурсан

ЗУРАГ 1.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН, АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД



Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2025 оны 4 дүгээр сард ажилгүй 108 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 32 иргэн ажилд зуучлагдан орж, 34 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Аймгийн хэмжээнд шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 12 (10%)-аар, ажилд зуучлагдан орсон иргэд 6 (15.8%)-аар тус тус буурсан байна.

ЗУРАГ 2.

АЖИЛ ХАЙЖ БҮРТГҮҮЛСЭН ИРГЭД



Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 82 (38.7%)-аар өссөн.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 153 (52%) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД



2025 оны 4 дүгээр сарын байдлаар Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайгчаар бүртгүүлсэн иргэд 108, үүнээс 87 (80.6%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 21 (19.4%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

ЗУРАГ 4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД



Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2025 оны 4 дүгээр сарын байдлаар ажилгүй 108 хүн шинээр бүртгүүлсний 11.1 хувийг ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан, өөрийн хүсэлтээр ажлаас гарсан

12 хувийг, шилжин суурьшсан 26.9 хувийг, малчин гэхдээ өөр ажил хайж байгаа 2.8 хувийг, ажилтай боловч өөр ажил хайж байгаа 19.4 хувийг тус тус эзэлж байна.


ЗУРАГ 5. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, БОЛОВСРОЛООР



Бүлэг 1. Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй таван хүн тутмын хоёр нь дипломын болон бакалаврын дээд, гурван хүн тутмын нэг нь бүрэн дунд боловсролтой байна.

ЗУРАГ 6. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 31.3 хувийг 25-34 насныхан, 32 хувийг 35-44 насныхан эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Ажил хайгч иргэн: Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Бүртгэлтэй ажилгүй иргэд: Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон

хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.



ЭРҮҮЛ МЭНД

Төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар буурчээ.

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 4 сарын байдлаар 332 эх амаржиж 335 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 28 (7.8%)-аар, төрсөн хүүхэд 25 (6.9%)-аар буурсан байна.

ХҮСНЭГТ 1. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн эхний 4 сарын байдлаар


Үзүүлэлт	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	2024 I-IV 2025 I-IV
	Тоо			Хувь
Амаржсан эх	438	360	332	-7.8
Амьд төрсөн хүүхэд	443	360	335	-6.9
Амьгүй төрсөн хүүхэд	1	4	-	-
Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөд ногдох)	1.8	11.1	-	-

*Урьдчилсан гүйцэтгэл

2025 оны эхний 4 сарын байдлаар амьд 335 хүүхэд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 28 (7.8%)-аар буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 170 (50.7%) нь эрэгтэй, 165 (49.3%) нь эмэгтэй байна. Амьд төрсөн хүүхдийн 13 (3.9%) нь бага жинтэй буюу 2500 гр-аас

доош жинтэй төржээ. Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд 332 (99.1%) байна.

ЗУРАГ 7. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



ХҮСНЭГТ 2.

НАС БАРАЛТ, ЭХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	<u>2025 I-IV</u> <u>2024 I-IV</u>
	Тоо			Хувь
Нас баралт	112	139	121	-12.9
Эмнэлэгт нас баралт	39	37	27	-27.0
Гэртээ /бусад газарт/	73	102	94	-7.8
Эхийн эндэгдэл	-	-	-	-
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	6	6	3	-50.0
Нялхасын эндэгдэл	5	6	2	-66.7
Нярайн эндэгдэл	3	5	-	-
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	13.5	16.7	9	-46.1
Нялхасын эндэгдлийн түвшин	11.3	16.7	6	-64.1
Нярайн эндэгдлийн түвшин	6.8	13.9	-	-

*Урьдчилсан гүйцэтгэл

2025 оны эхний 4 сарын байдлаар нийт нас баралтын 2.5 хувийг тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл эзэлж байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 болж өмнөх оны мөн үеэс 3 (50.0%)-аар буурсан

байна. Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 4 сарын байдлаар нялхасын эндэгдэл 2 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөд 6.0 ногдож байна.

ХҮСНЭГТ 3.

ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жилийн бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	<u>2025 I-IV</u> <u>2024 I-IV</u>
	Тоо			Хувь
Халдварт өвчнөөр өвлөгчид	159	133	341	2.6¹
Цусаар дамжих	2	1	-	-
Вирус гепатит	2	1	-	-
Гэдэсний халдварт	3	1	-	-
Цусан суулга	3	1	-	-
Сальмонолёз	-	-	-	-
Амьсгалын замаар дамжих	104	102	238	2.3¹
Сүрьеэ	24	22	18	-18.2
Салхин цэцэг	67	64	211	3.3 ¹
Гахайн хавдар	1	2	1	-50.0
Гар хөл амны өвчин	11	11	8	-27.3
Ковид 19	1	3	-	-
Бэлгийн замаар дамжих	48	29	37	1.3¹
Тэмбүү	15	11	18	1.6 ¹
Трихомониаз	16	3	5	1.7 ¹
Заг хүйтэн	17	15	14	-6.7
Бусад	1	-	65	-

¹ Дахин их

Бүлэг 2. Эрүүл мэнд

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2025 оны эхний 4 сарын байдлаар 341 болж, өмнөх оны мөн үеэс 208 (2.6 дахин)-аар өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Нийт халдварт өвчнүүд дотор БЗДХ 37 (10.8%), сүрьеэ 18 (5.3%), салхин цэцэг 211 (61.9%), тохиолдол гарч тус тус бүртгэгдсэн байна.

Амьгүй төрөлт: Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойших хугацаанд, 500 граммаас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нь ч (зүрхний цохилт, судасны лугшилт, булчингийн хөдөлгөөн) илрэхгүй байгааг хэлнэ.



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 42.2 (22.7%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2025 оны эхний 4 сарын байдлаар 23.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.1 (44.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 7.1 тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 5.6 (42.1%)

тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. Нийгмийн даатгалын сангийн зарлага 2025 оны эхний 4 сарын байдлаар 45.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.0 (24.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 7.4 (22.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

ХҮСНЭГТ 4.


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	<u>2025 I-IV</u> <u>2024 I-IV</u>
	сая төгрөг			хувь
Нийгмийн даатгалын сангийн нийт орлого	29 487.8	16 035.0	23 118.7	44.2
Тэтгэврийн даатгал	27 351.6	13 401.4	19 039.2	42.1
Тэтгэмжийн даатгал	877.3	1406.2	2 020.9	43.7
ҮОМШӨ-ний даатгал	933.8	958	1 363.3	42.3
Ажилгүйдлийн даатгал	325.1	269.4	695.3	58.1
Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага	28 254.1	36 313.6	45 352.5	24.9
Тэтгэврийн даатгал	25 622	33 007.6	40 428.6	22.5
Тэтгэмжийн даатгал	1 192.6	1 457.9	2 020.4	38.6
ҮОМШӨ-ний даатгал	1 029.2	1 387.8	1 747.8	25.9
Ажилгүйдлийн даатгал	410.2	460.2	1 155.7	51.1

*Урьдчилсан гүйцэтгэл

ЗУРАГ 8.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧИД, төрлөөр, 2025 оны эхний 4 сарын байдлаар



ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр

Үзүүлэлт	Тэтгэвэр, тэтгэмж авагчид			2025 I-IV 2024 I-IV	Олгосон мөнгө			2025 I-IV 2024 I-IV
	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV		2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	
	хүн			хувь	сая төгрөг			хувь
Тэтгэвэр	12 888	13 230	15 930	20.4	25 610.3	32 971.0	40 422.6	22.6
Өндөр настны	10 150	11 124	13 085	17.6	21 164.6	30 492.8	33 575.0	10.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	1 520	1 323	1 618	22.3	2 583.7	1 338.0	3 919.5	2.9 ¹
Тэжээгчээ алдсаны	563	525	549	4.6	1 022.2	512.7	1 384.0	2.7 ¹
Цэргийн	256	258	270	4.7	839.8	627.6	1 544.1	2.5 ¹
ҮОМШӨ-ний тэтгэвэр	399	383	408	6.5	1 001.7	1 387.8	1 747.8	25.9
Тэтгэмж	1 963	644	1 118	73.6	1 149.9	1 457.1	2 019.9	38.6
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	1 313	176	613	3.5 ¹	231.6	230.4	294.3	27.8
Жирэмсэний болон амаржсаны	385	334	388	16.2	696.3	958.7	1 491.6	55.6
Оршуулгын	111	134	117	-12.7	222.0	268.0	234.0	-12.7
Ажилгүйдлийн тэтгэмж	154	538	309	-42.6	405.1	460.2	1 155.7	2.5¹

¹Дахин их

Тэтгэврийн даатгалын сангаас 2025 оны эхний 4 сарын байдлаар 15 930 хүнд 40.4 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэвэр авагчид 2 700 (20.4%) хүнээр өсөж, олгосон тэтгэврийн хэмжээ 7.5 (22.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас 2025 оны эхний 4 сарын байдлаар 408 хүнд 1.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэвэр авагчид 25 (6.5%) хүнээр өсөж, олгосон тэтгэврийн хэмжээ 0.3 (25.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас 2025 оны эхний 4 сарын байдлаар 1 118 хүнд 2.0 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмж авагчид 474 (73.6%) хүнээр өсөж, олгосон тэтгэмжийн хэмжээ 0.05 (38.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2025 оны эхний 4 сарын байдлаар 309 хүнд 1.2 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмж авагчид 229 (42.6%) хүнээр буурч, олгосон тэтгэмжийн хэмжээ 0.7 (2.5 дахин) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн сангаас 2025 оны эхний 4 сарын байдлаар 130 400 (давхардсан тоогоор) мянган хүнд 16.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгосон байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн 0.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 0.4 хувь нь ахмад настан, 67.2 хувь нь хүүхэд байна.

ХҮСНЭГТ 6.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр

Үзүүлэлт	Нийгмийн халамжинд хамрагдагчид	Олгосон мөнгө
	2025 I-IV	2025 I-IV
	хүн	сая төгрөг
0-18 хүртлэх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	295	186.8
Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хөнгөлөлт	513	69.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	322	25.1
Жирэмсэн эхийн тэтгэмж	1 381	51.5
0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	8 026	395.6
Ихэр хүүхдийн тэтгэмж	2	4.0
Эхийн алдар одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламж	7 396	1 878.3
Насны хишиг	4 840	380.0
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	87 575	8 837.3
Алдар цолтон ахмад настанд олгох нэмэгдэл, хөнгөлөлт	7	0.8
Халамжийн тэтгэвэр	5 213	2 091.6
Асаргааны тэтгэмж	6 171	1 835.2
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	2 921	548.6
Ахмадын оршуулгын тэтгэмж	3	6.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний оршуулгын тэтгэмж	6	12.0
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	5 722	103.6
Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж	7	8.4
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	-	-

*Урьдчилсан гүйцэтгэл

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн: Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ.

Нийгмийн халамж: Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Ахмад настан: Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг хэлнэ. нас барах тохиолдолд гэр бүлд нь хуульд заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.



ГЭМТ ХЭРЭГ


Гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 46.6 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2025 оны эхний 4 сарын байдлаар 302 болж, өмнөх оны мөн үеэс 96 (46.6%)-

өөр өссөн. Үүнээс 233 (77.2%) нь хөнгөн гэмт хэрэг, 69 (22.8%) нь хүнд гэмт хэрэг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 9.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



ЗУРАГ 10.


СОГТУУГААР БОЛОН БҮЛЭГЛЭН ҮЙЛДСЭН ХЭРЭГ, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	$\frac{2025\ I-IV}{2024\ I-IV}$
Согтуугаар үйлдсэн	50	70	79	12.9
Бүлэглэн үйлдсэн	15	8	11	37.5

Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 2025 оны эхний 4 сарын байдлаар 79, өмнөх оны мөн үеэс 9 (12.9%)-аар, бүлэглэн үйлдсэн хэрэг 11, өмнөх оны мөн үеэс 3 (37.5%)-аар тус тус өссөн байна.

ЗУРАГ 11.

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, эхний 4 сарын байдлаар



Бүлэг 4. Гэмт хэрэг

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2025 оны эхний 4 сарын байдлаар 908.0 мянган төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 816.2 (47.3%) мянган төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 7.

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ГЭМТСЭН, НАС БАРСАН ХҮН, эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	$\frac{2025\text{ I-IV}}{2024\text{ I-IV}}$
Нас барсан хүн	14	4	8	2.0 ¹
Гэмтсэн хүн	53	66	59	-10.6


¹ Дахин их

Гэмт хэргийн улмаас 2025 оны эхний 4 сарын байдлаар 59 хүн гэмтсэн, өмнөх оны мөн үетэй

харьцуулахад 7 (10.6%)-оор, буурсан бол 8 хүн нас барж өмнөх оны мөн үеэс 4 (2.0 дахин)-өөр өссөн байна.

ЗУРАГ 12.

ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ЯЛЛАГДАГЧ, эхний 4 сарын байдлаар




Гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчийн тоо 2025 оны эхний 4 сарын байдлаар 157 болж, өмнөх оны мөн үеэс 4 (2.5%)-өөр өссөн байна. Нийт гэмт хэрэгт

холбогдсон яллагдагчийн 24 (15.3%) нь эмэгтэй байна.

ЗУРАГ 13.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН БҮТЭЦ, эхний 4 сарын байдлаар



Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 4 сарын байдлаар нийт 15 504 зөрчил бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 265 (1.7%)-аар, жолоодох эрхээ хасуулсан хүн өмнөх оны мөн үеэс 98 (84.5%)-оор тус тус өссөн бол баривчлагдсан хүн өмнөх оны мөн үеэс 31 (26.2%)-аар буурсан байна.

Бүлэг 4. Гэмт хэрэг

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.

16. түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд

хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.



МӨНГӨ

Төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 33.1 хувиар өсжээ.


Арилжааны банкууд дахь нийт хадгаламж 2025 оны 4 дүгээр сард 185.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 46.2 (25%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт хадгаламжийн 149.9 (80.6%) тэрбум төгрөг нь хугацаатай, 34.7 (19.4%) тэрбум төгрөг нь хугацаагүй хадгаламж байна.

ХҮСНЭГТ 8. НИЙТ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ, төрлөөр, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	2024 IV	2025 IV	Зөрүү	
	тэрбум төгрөг		дүн	хувь
Нийт зээлийн үлдэгдэл	265.8	417.5	151.7	57.1
Хэвийн зээлийн үлдэгдэл	258.9	406.4	147.5	57.0
Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл	3.7	5.5	1.8	48.6
Чанаргүй зээлийн үлдэгдэл	3.2	5.6	2.4	75.0
Нийт харилцахын үлдэгдэл	51.6	64.5	12.9	25.0
Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	139.7	185.9	46.2	33.1
Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	29.0	34.7	5.7	19.7
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	110.7	149.9	39.2	35.4
Нийт банкны салбар, нэгжийн тоо	49	50	1.0	2.0
Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо	232	218	-14.0	-6.0
Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)	44 274	50 850	6576	14.9
Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	147 336	138 591	-8745	-5.9
Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	57 180	60 787	3607	6.3
Нийт АТМ-ны тоо	40	43	3.0	7.5
Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо	71 749	70 660	-1089	-1.5


ЗУРАГ 14. НИЙТ ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, төрлөөр, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар




Нийт зээлийн өрийн үлдэгдэл 2025 оны 4 дүгээр сарын байдлаар 417.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 151.7 (57.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт зээлийн өрийн үлдэгдэлийн 5.5 (1.3%) тэрбум төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 5.6 (1.3%) тэрбум төгрөгийг чанаргүй зээл эзэлж байна.

ЗУРАГ 15. НИЙТ ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ



ЗУРАГ 16. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ДАНС ЭЗЭМШИГЧИД



2025 оны 4 дүгээр сарын байдлаар нийт зээлийн данс эзэмшигчид 50 850 болж, өмнөх оны мөн үеэс 6 576 (14.9%) -аар, хадгаламжийн данс эзэмшигчид 60 787

болж, өмнөх оны мөн үеэс 3 607 (6.3%)-оор тус тус өссөн байна.

ЗУРАГ 17. ХЭНТИЙ АЙМАГ ДАХ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ

Сумын нэрс	2024. IV		2025. IV	
	Нийт зээл	Нийт хадгаламж	Нийт зээл	Нийт хадгаламж
Аймгийн төв	123 426.5	62 533.2	176 117.7	83 322.7
Үүнээс салбар	37 828.8	24 008.2	66 806.2	35 353.6
Үүнээс тооцооны төв	85 597.8	38 525.0	109 311.5	47 969.1
Батноров	17 553.7	9 345.0	22 526.9	11 452.5
Батширээт	7 075.9	3 596.1	8 322.5	5 651.7
Баян-Адарга	8 409.2	2 581.3	9 199.2	3 946.1
Баянмөнх	5 464.4	2 163.0	8 226.7	2 373.4
Баян-Овоо	7 559.0	2 271.1	8 862.2	2 561.9
Баянхутаг	5 258.4	1 015.4	6 245.4	1 686.6
Биндэр	10 397.8	6 523.0	12 835.8	8 377.5
Бор-Өндөр	48 762.9	16 579.3	63 004.5	23 994.5
Галшар	7 258.0	1 766.5	8 919.9	1 989.9
Дадал	8 471.2	4 362.2	11 008.8	4 602.7
Дархан	8 649.6	4 748.0	10 753.2	4 545.2
Дэлгэрхаан	8 898.7	2 591.3	10 066.1	3 308.3
Жаргалтхаан	7 092.5	4 171.7	7 931.9	5 465.9
Мөрөн	7 449.4	628.0	10 603.1	1 081.3
Норовлин	9 843.9	5 851.7	13 072.3	8 210.3
Өмнөдэлгэр	19 167.9	6 991.0	21 238.5	9 505.0
Цэнхэрмандал	7 176.0	2 196.5	8 520.8	2 999.6
Нийт	317 915.1	139 914.3	417 455.4	185 075.1

Бүлэг 5. Мөнгө, зээл

Ойлголт, тодорхойлолт:

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно



АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСӨВ


Аймгийн нэгдсэн төсвийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар өссөн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2025 оны эхний 4 сарын урьдчилсан байдлаар 40 481.1 сая төгрөг байна. Орон нутгийн төсвийн нийт

зарлага, цэвэр зээлийн дүн 29 224.4 сая төгрөг болж, төсвийн тэнцэл 11 256.7 сая төгрөгийн ашигтай гарлаа.

ЗУРАГ 18.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТЭНЦЭЛ, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 4 САРЫН БАЙДЛААР, САЯ ТӨГРӨГ



Орон нутгийн төсвийн орлогын 36.8 хувийг татварын орлого, 63.2 хувийг татварын бус орлого тус тус эзэлж байна. Татварын орлого 2025 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 14 898.1 сая төгрөг

болж, өмнөх оны мөн үеэс 2 709.3(22.2%) сая төгрөгөөр, татварын бус орлого 25 583.0 сая төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 1 442.9 (6%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.


ХҮСНЭГТ 9.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 4 САРЫН БАЙДЛААР

Орлогын төрөл	2023	2024	2025*	2025 I-IV*
	I-IV	I-IV	I-IV	2024 I-IV
	сая төгрөг			
НИЙТ ОРЛОГО, ТУСЛАМЖИЙН ХЭМЖЭЭ	18 815.6	36 328.9	40 481.1	11.4
ТАТВАРЫН ОРЛОГО	5 731.7	12 188.8	14 898.1	22.2
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	.	990.0	3 557.7	3.6 ¹
Орлогын албан татвар	4 129.3	9 197.4	8 526.5	- 7.3
Хөрөнгийн албан татвар	606.9	653.7	907.8	38.9
Бусад татвар, төлбөр, хураамж	995.5	1 347.7	1 906.1	41.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	596.3	24 140.1	25 583.0	6.0
Нийтлэг татварын бус орлого	478.6	622.9	1 191.5	91.3
Хөрөнгийн орлого	117.4	68.3	1.3	- 98.1
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	2 803.4	23 448.9	24 390.2	4.0
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	2 475.9	-	-	-
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	-	4 637.6	2 544.3	-45.1
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7 090.9	-	-	-
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	-	14 094.2	13 616.5	- 3.4

ЗУРАГ 19.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮТЭЦ




Татварын орлогод 2025 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр орлогын албан татвар 57.2 хувь, хөрөнгийн албан татвар 6.1 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 23.9 хувийг, бусад татвар, төлбөр, хураамж 12.8 хувийг эзэлж байна. Татварын нийт орлогод орлогын албан татварын

эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 18.3 хувь нэгжээр, буурсан бол хөрөнгийн албан татварын эзлэх хувь 0.7 хувь нэгжээр, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 15.8 хувь нэгжээр, бусад татвар, төлбөр, хураамжийн эзлэх хувь 1.7 хувь нэгжээр тус тус өссөн байна.

ЗУРАГ 20.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГО, НИЙТ ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛ



Орон нутгийн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2025 оны эхний 4 сарын урьдчилсан байдлаар 29 224.4 сая төгрөг

болж, өмнөх оны мөн үеэс 3 915.5 (15.5%) сая төгрөгөөр өссөн байна.


ХҮСНЭГТ 10.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛ, эхний 4 сарын байдлаар

Зарлагын төрөл	2023	2024	2025 *	2025 IV*
	I-IV	I-IV	I-IV	2024 IV
	сая төгрөг			хувь
НИЙТ ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ	17 196.9	25 308.9	29 224.4	15.5
НИЙТ ЗАРЛАГА	16 725.3	25 166.6	28 954.1	15.0
УРСГАЛ ЗАРДАЛ	13 118.2	20 910.8	25 715.1	23.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12 865.2	19 936.1	25 062.4	25.7
ТАТААС	-	123.7	2.0	-98.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77.5	851.0	650.7	-23.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	123.9	150.1	230.1	53.3
Бусад урсгал шилжүүлгүүд	25.2	700.9	420.6	-40.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4 255.8	3 239.0	-23.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	471.6	142.3	270.3	90.0

ЗУРАГ 21.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН БҮТЭЦ



Урсгал зардалд бараа, ажил үйлчилгээний зардал 97.5 хувь, урсгал шилжүүлэг 2.5 хувийг эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв

орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 6.6 хувь, өмнөх сараас 0.8 хувиар өссөн байна.

ЗУРАГ 22. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 4 дүгээр сарын байдлаар өмнөх сараас 0.8 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 2.8 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 4 дүгээр сарын байдлаар өмнөх оны эцсээс 2.6 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 5.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 3.5 хувь, даатгал, санхүүгийн

үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.3 хувь, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 5.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 4 дүгээр сарын байдлаар өмнөх оны үеэс 6.6 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 8.6 хувь, согтууруулах ундаа, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 2.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 19.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 7.3 хувь, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 6.0 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 11.

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2025 оны 4 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	2025 IV 2024 IV	2025 IV 2024 XII	2025 IV 2024 III
ЕРӨНХИЙ ИНДЕКС	6.6	2.6	0.8
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	8.6	5.8	2.8
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	2.5	1.1	0.1
Хувцас, бөс бараа, гутал	7.2	0.7	-
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	19.6	3.5	-
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	6.6	0.8	-
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	3.7	1.5	-
Тээвэр	-2.2	0.6	0.1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	-	-	-
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	1.5	0.9	0.3
Боловсролын үйлчилгээ	-	-	-
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	7.3	3.3	-
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	4.3	4.3	1.2
Бусад бараа, үйлчилгээ	6.0	5.4	1.0

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 4 дүгээр сард 4.7 хувь гарсан бол 2025 оны 4 дүгээр сард 0.8 хувь болж өмнөх оны мөн үеэс 3.9 нэгж хувиар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал: ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – тайлант үеийн хувиргасан Ласпейресийн индекс (t)
 t – тайлант үе
 i – бараа, үйлчилгээ
 o – суурь үе
 P_{it} - i барааны тайлант үеийн үнэ
 P_{i0} - i барааны суурь үеийн үнэ
 Q_{i0} - i барааны суурь үеийн жин

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 404 бараа, үйлчилгээ (аймагт 313 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2018, 2019, 2020 оны дундаж үр дүнгээр жинг тооцон, 2020 оны шинэчилсэн суурьтайгаар 2022 оны 8 дугаар сараас эхлэн тархааж байна. Хэрэглээний үнийн индексийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.



МАЛ АЖ АХУЙ

Аймгийн хэмжээнд төл бойжилт 99.7 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1673.3 мянган хээлтэгч малын 927.7 мянга (55.4%) нь 2025 оны эхний 4 сарын байдлаар төллөсөн байна.


ХҮСНЭГТ 12. МАЛ ТӨЛЛӨЛТ, ЭХ МАЛЫН ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 4 САРЫН БАЙДЛААР, МЯНГАН ТОЛГОЙ

Эх малын төрөл	Оны эхний хээлтэгч		Хорогдсон хээлтэгч		Төллөсөн хээлтэгч	
	2024	2025	2024 I-IV	2025 I-IV	2024 I-IV	2025 I-IV
Бүгд	2 241.6	1 673.3	484.9	2.5	381.0	927.7
Гүү	124.7	110.5	29.6	0.2	9.8	32.7
Үнээ	165.3	146.1	36.4	0.2	21.0	58.9
Ингэ	1.6	1.4	0.1	0.0	0.2	0.2
Эм хонь	1 219.1	823.6	270.4	1.4	222.1	493.7
Эм ямаа	730.9	591.7	148.4	0.7	127.8	342.1

Эм хонины 493.7 мянга буюу 60.0 хувь, эм ямааны 342.1 мянга буюу 57.8 хувь, ингэний 0.2 мянга буюу

16.6 хувь, үнээний 58.9 мянга буюу 40.3 хувь, гүүний 32.7 мянга буюу 29.6 хувь нь төллөсөн байна.

ЗУРАГ 23. ТӨЛЛӨЛТИЙН ХУВЬ, ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 4 САРЫН БАЙДЛААР, ХУВИАР



Гарсан төлийн 99.7 хувь буюу 926.8 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 579.3 (62.5%) мянгаар өссөн байна. Хурганы 493.3 мянга буюу 99.7 хувь, ишигний 341.8 мянга буюу 99.8, тугалын 58.8 мянга буюу 99.8 хувь, унаганы 32.6 мянга буюу 99.8 хувь, ботгоны 0.2 мянга буюу 99.6 хувь нь бойжсон байна.

ХҮСНЭГТ 13. БОЙЖУУЛСАН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, мянган толгой

Төлийн төрөл	Гарсан төл		Бойжуулсан төл		Төл бойжилтын хувь	
	2024 I-IV	2025 I-IV	2024 I-IV	2025 I-IV	2024 I-IV	2025 I-IV
Бүгд	381.7	929.8	347.5	926.8	91.0	99.7
Унага	9.9	32.7	9.0	32.6	91.3	99.8
Тугал	21.0	58.9	19.8	58.8	94.4	99.8
Ботго	0.2	0.2	0.2	0.2	92.8	99.6
Хурга	222.4	494.8	203.0	493.3	91.3	99.7
Ишиг	128.2	343.2	115.5	341.8	90.0	99.8

Том малын зүй бус хорогдол 2025 оны эхний 4 сард аймгийн хэмжээнд 3.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 957.0 (99.7%) мянгаар буурсан байна. Нийт хорогдол нь оны эхний малын 0.1 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, ямаа 1.1 мянга, хонь 1.8 мянга, үхэр 0.3 мянга, адуу 0.2 мянгаар тус тус хорогдсон байна. Тэмээний хорогдол байхгүй байна. Нийт хорогдсон малын 52.9 хувийг хонь, 32.4 хувийг ямаа эзэлж байна.


ХҮСНЭГТ 14. ХОРОГДСОН ТОМ МАЛ, төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, мянган толгой

Малын төрөл	Хорогдсон том мал			Оны эхний малд хорогдлын эзлэх хувь		
	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV
	мянган толгой			хувь		
Дүн	165.6	960.4	3.4	3.3	21.8	0.11
Адуу	7.8	63.9	0.2	2.1	17.8	0.09
Үхэр	13.5	77.2	0.3	3.1	19.0	0.09
Тэмээ	0.01	0.2	0.0	0.9	5.0	0.0
Хонь	77.1	526.5	1.8	2.9	23.2	0.12
Ямаа	67.2	292.6	1.1	4.1	21.4	0.1

Хорогдлыг сумаар нь авч үзэхэд 2025 оны эхний 4 сарын байдлаар Норовлин сум 0.9 (26.5 хувь) мянга, Баян-овоо 0.4 (11.8 хувь) мянга, Өмнөдэлгэр 0.3 (8.8 хувь) мянга, Жаргалтхаан сум

0.2 (5.9 хувь) мянган толгой мал хорогдсон нь нийт хорогдлын 52.9 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 24. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, сумаар



Бүлэг 8. Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2024 оны эцэст тоологдсон 1673.3 мянган эх малын 2.5 мянга (0.1%) нь 2025 оны эхний 4 сард хорогдсон байна. Хэрлэн, Батноров, Баян-Адрага, Баян-овоо Жаргалтхаан, Норовлин, Өмнөдэлгэр сумдад 123-706 толгой хээлтэгч мал хорогдсон нь нийт

хорогдсон хээлтэгчийн 83.1 хувийг эзэлж байна. Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 4 сард 345 мал өвчнөөр хорогдсож байсан бол 2025 оны эхний 4 сард өвчөөр мал хорогдоогүй байна.

Ойлголт, тодорхойлолт:

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулж тооцно.

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Төл бойжилтын хувь: Бойжуулсан төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж тооцно.



АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 52.6 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 84.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 29.1 (52.6%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай олборлолт 28.4 (59.4%) тэрбум төгрөг, боловсруулах үйлдвэрлэл 0.3 (29.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.


Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 76.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 28.4 (59.4%) тэрбум төгрөгөөр өсөхөд төмрийн хүдэр олборлолт 5.7 (50.8%) тэрбум төгрөг, хайлуур жонш олборлолт 0.9 (15.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛТ, салбараар, сая төгрөг

Салбар	Жил			Сар			2025 I-IV 2024 I-IV	
	2022	2023	2024	2023 I-IV	2024 I-IV	2025* I-IV	Дүн	Хувь
Нийт дүн	121 213.5	128 348.8	185 182.6	36 907.7	55 310.6	84 402.5	29 091.9	52.6
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	110 396.7	115 495.4	168 111.9	31 190.3	47 837.4	76 257.8	28 420.4	59.4
Боловсруулах аж үйлдвэр	1 639.8	2 030.0	3 079.3	653.8	1 043.7	1 352.9	309.2	29.6
Цахилгаан хий, уур, агааржуулалт	7 682.6	8 836.8	11 367.8	4 293.6	5 502.8	5 632.6	129.8	2.4
Ус хангамж, сувагжилтын систем	1 494.4	1 986.6	2 623.5	770.0	926.7	1 159.2	232.5	25.1

*Урьдчилсан гүйцэтгэл

ЗУРАГ 25. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, сая төгрөг



Бүлэг 9. Аж үйлдвэр

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал, хайлуур жоншны биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 23.1 – 61.4 хувиар өсөж, харин хүрэн нүүрс олборлолт 31.5 хувиар буурчээ.


Боловсруулах аж үйлдвэрийн салбарт нарийн боов, тавилга, монгол дээл зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 8.5 – 70.1 хувиар өсөж, харин бялуу, хиам, талх, цэвэр ус, хэрчсэн гурил зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 7.5 – 34.1 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ


Бүтээгдэхүүн	2024		2025*		2025 I-IV 2024 I-IV	
	IV	I-IV	IV	I-IV	Дүн	Хувь
Уул уурхай, олборлох аж үйлдвэр						
Хүрэн нүүрс, бөөгнөрөөгүй, мянган тонн	2.9	16.3	3.2	11.2	-5.1	-31.5
Төмрийн хүдэр, мянган тонн	204.9	527.3	204.4	669.8	142.5	27.0
Төмрийн хүдрийн баяжмал, мянган тонн	62.8	221.0	82.4	356.8	135.8	61.4
Хайлуур жонш, мянган тонн	10.6	43.2	11.7	53.2	10.0	23.1
Боловсруулах үйлдвэр						
Хиам, тонн	1.5	7.2	1.5	6.3	-0.9	-12.5
Талх, тонн	18.3	73.4	14.2	56.5	-16.9	-23.0
Нарийн боов, тонн	6.3	31.9	7.3	34.6	2.7	8.5
Бялуу, тонн	1.1	4.0	0.9	3.7	-0.30	-7.5
Банш, бууз, хуушуур, тонн	-	-	1.4	6.8	6.8	-
Цэвэр ус, мянган литр	19.0	79.0	16.0	61.3	-17.7	-22.4
Бөөрөнхий мах, котлет, килограмм	-	-	189	904	904	-
Хэрчсэн гурил, тонн	0.7	4.1	0.8	2.7	-1.4	-34.1
Монгол дээл, тэрлэг, ширхэг	30.0	97.0	20.0	165.0	68.0	70.1
Бусад оёмол даавуун хувцас, эдлэл ширхэг	51.0	248.0	35.0	120.0	-128.0	-51.6
Гуалин, метр куб	70.0	556.0	32.0	262.0	-294.0	-52.9
Банз, метр куб	40.0	68.0	85.0	224.0	156.0	3.3*
Модон байшингийн хийц, ширхэг	200.0	600.0	60.0	170.0	-430.0	-71.7

*Урьдчилсан гүйцэтгэл

ЗУРАГ 26. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, сая төгрөг



Бүлэг 9. Аж үйлдвэр



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2025 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 87.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.5 (0.6%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Үүнд боловсруулах салбарын борлуулалт 0.5 (36.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 17. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сая төгрөг

Салбар	Жил			Сар			2025 I-IV 2024 I-IV	
	2022	2023	2024	2023 I-IV	2024 I-IV	2025* I-IV	Дүн	Хувь
Нийт дүн	91 053.3	239 640.8	354 376.3	94 329.5	86 628.1	87 164.4	536.3	0.6
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	80 770.0	226 511.5	338 395.6	88 841.3	79 731.0	79 184.1	546.9	-0.7
Боловсруулах аж үйлдвэр	2 079.1	2 570.7	3 719.0	777.0	1 254.4	1 708.6	454.2	36.2
Цахилгаан хий, уур, агааржуулалт	6 702.3	8 568.1	9 630.2	3 948.3	4 710.3	5 079.4	369.1	7.8
Ус хангамж, сувагжилтын систем	1 502.0	1 990.5	2 631.6	762.9	932.4	1 192.3	259.9	27.9

*Урьдчилсан гүйцэтгэл

Ойлголт, тодорхойлолт:

Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал: НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн (биет хэмжээний) индекс: Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, Ласпейсийн биет хэмжээний индексийн томъёог ашиглан тооцно.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.



АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Аймгийн хэмжээнд агаарын температур 4 дүгээр сард хамгийн хүйтэн -14.1 °C хүрсэн байна.

Хэнтий аймгийн хэмжээнд Агаарын үнэмлэхүй их температур 2025 оны дүгээр сард үнэмлэхүй их Галшар + 25.6 0C, үнэмлэхүй бага температур Батширээт суманд - 14.1 0C-д хүрлээ. Хамгийн их хур тунадасны нийлбэр 2025 оны 4 дүгээр сард Дадал суманд 21.2 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Өмнөдэлгэр сумын нутгаар түр зуур 26 м/с-д хүрсэн байна.

АГААРЫН ЧАНАР

Чингис хотод 2025 оны 4 дүгээр сард агаар дахь хүхэрлэг хийн сарын дундаж агууламж 0.06 мг/м3-д хүрч агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас даваагүй байна. Мөн азотын давхар ислийн сарын дундаж агууламж 0.023 мг/м3-д хүрч агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас даваагүй байна.

ХҮСНЭГТ 18.

АГААРЫН ЧАНАР, 4 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	Дундаж	Хамгийн их	Хүлцэх агууламжаас давсан
	2025 IV	2025 IV	2025 IV
Хүхэрлэг хий SO ₂	0.006	0.016	байхгүй
Азотын давхар исэл NO ₂	0.023	0.054	байхгүй

Эх үүсвэр: Хэнтий аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв

Ойлголт, тодорхойлолт

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавж, мэрэгч тархах зэргийг хэлнэ.

Гамшиг: Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.


Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

ХЭНТИЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Г.СЭДЭДМАА

2025 оны 5 дугаар сарын 15



khentii.nso.mn



Хэнтий аймгийн
статистикийн хэлтэс



khentii@nso.mn



7056 2303
7056 2348